



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-18

1.Хууль зүйн дүгнэлт гаргуулах тухай /Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн талаар/	6-13
2.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	13-14
3.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	15-16
4.“Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	17-18

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 09-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 27 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 45 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, О.Номинчимэг, С.Эрдэнэболд;
Чөлөөтэй: С.Амарсайхан, Х.Баттулга, М.Нарантуяа-Нара;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Ганбат, Л.Мөнхбаатар, П.Сайнзориг, Б.Тулга, Х.Тэмүүжин;
Тасалсан: Б.Дэлгэрсайхан, Д.Пүрэвдаваа.

Нэг.Хууль зүйн дүгнэлт гаргуулах тухай /Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн талаар/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын ахлах зөвлөх С.Энхцэцэг, Ж.Бямбадулам нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн “11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт энэ хууль 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд үйлчилнэ” гэж тусгасан нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль хүчин төгөлдөр болох хугацааны тухай зохицуулалттай нийцэж байгаа эсэх талаар гаргасан хууль зүйн зөвлөмжийг Хуулийн газрын ахлах зөвлөх С.Энхцэцэг танилцуулав.

Хууль зүйн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн тавьсан асуултад Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн “11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт энэ хууль 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд үйлчилнэ” гэж тусгах нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль хүчин төгөлдөр болох хугацааны тухай зохицуулалттай нийцэж байгаа гэсэн хууль зүйн зөвлөмжийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарсан зөвлөмжийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэхээр тогтов.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг дагаж мөрдөх хугацаа тодорхой бус байх нь Хууль тогтоомжийн тухай хуулийн “27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт”, 28 дугаар зүйлийн 28.3.9 дэх заалттай тус тус зөрчилдсөн эсэх талаарх хууль зүйн зөвлөмжийг Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг дагаж мөрдөх хугацаа нь тодорхой бус байх нь Хууль тогтоомжийн тухай хуулийн “27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт”, “28 дугаар зүйлийн 28.3.9 дэх заалт”-тай тус тус зөрчилдсөн гэсэн хууль зүйн зөвлөмжийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарсан зөвлөмжийг Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодод хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 12 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг

бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 4

Бүгд: 14

71.4 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, О.Алтангэрэл, Х.Баасанжаргал, П.Сайнзориг, С.Одонтуяа, Д.Пүрэвдаваа нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Х.Баасанжаргал, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, Д.Пүрэвдаваа нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг үг хэлэв.

Д.Цогтбаатар: “Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 6

Бүгд: 14

57.1 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 51 минут үргэлжилж, 27 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 36 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 11 цаг 45 минут

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Энхбаярын Батшугар, Баярмагнайн Баярбаатар, Жудгийн Баярмаа, Гонгорын Дамдинням, Салдангийн Одонтуяа, Бөхчулууны Пүрэвдорж, Ухнаагийн Отгонбаяр, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар гэсэн гишүүдийн ирцтэйгээр ирц 51.9 хувиар бүрдсэн тул ингээд хурал нээгдлээ. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр 4 асуудал байж байгаа.

Нэгдүгээр асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай.

Хоёрдугаар асуудал нь, Байнгын хорооны тогтоолын төсөл, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай.

Гуравдугаар асуудал нь, Байнгын хорооны тогтоолын төсөл, Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай.

Дөрөвдүгээр асуудал. Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт энэ хууль 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд үйлчилнэ гэж тусгасан нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль хүчин төгөлдөр болох хугацааны тухай зохицуулалттай нийцэж байгаа эсэх талаар хууль зүйн зөвлөмж. Төсвийн хороо болон БОХХАА-н байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний тогтоолд нэмэлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн дагаж мөрдөх хугацаа нь тодорхой бус байх нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар

зүйлийн 27.1.1 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.3.9 дэх заалттай тус тус зөрчилдсөн эсэх талаарх хууль зүйн зөвлөмж гэсэн ийм 4 асуудал байгаа.

Тэгэхээр хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байвал нэрээ өгье.

Дамдинням гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүний микрофоныг өгье.

Г.Дамдинням: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Энэ хэлэлцэх асуудлын дараалал өөрчлөх горимын санал гаргаж байна.

Яагаад вэ гэвэл хажууд Эдийн засгийн байнгын хороо хуралдах гээд бас бэлэн болчихсон. Тэгээд энэ стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн талаар Их Хурлаас нөгөө зөвлөмж Хууль зүйн байнгын хорооноос зөвлөмж авъя аа гэж шийдсэн. Зөвлөмжийг 1 дүгээр асуудал болгож хэлэлцээд Их Хурлын хууль зүйн зөвлөмжөө сонсчихоод нэг санал хураалт хураагаад тэгээд Эдийн засгийн байнгын хороогоор оруулах ёстой юм байгаа юм.

Тэгэхээр энийг эхний асуудал болгож оруулж өгөөч ээ гэж хүсэлт тавьж байна.

Д.Цогтбаатар: Дамдинням гишүүн ийм горимын санал гаргаж байна.

Энэ миний хувьд бол хэдүүлээ дэмжээд санал хураагаад энийгээ явчихъя. Яагаад гэвэл Байнгын хороод бие биедээ бас хүндэтгэлтэй хандаж байх ёстой байх. Манайхыг хүлээгээд байгаа юм байна. Тэгвэл Дамдинням гишүүний саналыг 4 дүгээр асуудлыг 1 дүгээр асуудал болгоод хэлэлцэх тухай саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй.

Түрүүн томъёоллыг танилцуулчихсан. Санал хураалт.

Түр хүлээгээрэй түр зогсооё.

Наадах чинь хааяа ингээд гацаад байдаг юм.

Техникийн санал хураалт хийгээд үзье дээ. Манайхан дэмжсэн гээд үзээд өгөөд үз дээ. Санал хураалт.

Санал хураалт 64.3 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд 1 дүгээр асуудал Эдийн засгийн байнгын хороотой холбоотой асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалдаа орёё.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт энэ хууль 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд үйлчилнэ гэж тусгасан нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль хүчин төгөлдөр болох хугацааны тухай зохицуулалттай нийцэж байгаа эсэх талаар гаргасан хууль зүйн зөвлөмжийг

Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа танилцуулна аа. 4 дүгээр микрофон өгье. Ахлах зөвлөх Энхцэцэг танилцуулъя.

С.Энхцэцэг: Хууль зүйн зөвлөмж гаргах үндэслэл.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргуулахаар Эдийн засгийн байнгын хорооноос Улсын Их Хурлын Тамгын газарт 2025 оны 12 сарын 8-ны өдөр ирүүлсэн УИХ 0913991 дугаартай албан бичиг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2-т заасан дагуу энэхүү зөвлөмжийг гаргалаа. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд тусгасан хуулийн үйлчлэх хугацаа нь Хууль тогтоомжийн тухай хуульд нийцэж байгаа эсэх талаар, хуулийн төслийн хуулийн үйлчлэх хугацаа гэсэн 11 дүгээр зүйлийн 11.10 11.1-д энэ хууль 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд үйлчилнэ гэж тусгажээ. Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд хуулийн хүчин төгөлдөр болох хугацааны талаар тусгана гэж хуулийн төсөл боловсруулах гэсэн 16 дугаар зүйлийн 16.2-т хууль тогтоомжийн төслийг энэ хуулийн 4 дүгээр бүлэг болон 12.1.1-д заасан аргачлалын дагуу боловсруулна гэж, 12 дугаар зүйлийн 12.1.1-д Засгийн газар хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баталж мөрдүүлнэ гэж, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 3.6.6.5-д хууль зөвхөн тодорхой хугацаанд үйлчлэхээр байвал түүний хүчин төгөлдөр болох болон хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа дуусгавар болох огноог хуульд заана гэж тус тус заасан байна аа.

Дээрх зохицуулалтуудаас үзэхэд хууль санаачлагч хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газраас баталсан аргачлалын дагуу боловсруулах шаардлагатай бөгөөд хэрэв тухайн хууль тодорхой хугацаанд үйлчлэхээр байвал хууль хүчин төгөлдөр болох хугацааг хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа дуусгавар болох огнооны хамт хуулийн төсөлд тодорхой тусгахаар аргачлал заажээ.

Гэтэл хуулийн төслийн 11.11 дүгээр зүйлийн 11.1-д уг хууль 2030 хоног дуустал хугацаанд үйлчлэхээр тусгасан мөртөө хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар заагаагүй нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасан шаардлагыг хангахгүй байна. Иймд хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хийхдээ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2-т заасны дагуу Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн төсөлд хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэх тодорхой хугацааг нэмж тусгах нь зүйтэй байна аа.

Санал зөвлөмж

1.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хууль нь тодорхой хугацаанд үйлчлэхээр байх тул төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт хууль хүчин төгөлдөр болох хугацааг нэмж тусгах.

2.Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2-т заасны дагуу хийхийг зөвлөж байна.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтой оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын ахлах зөвлөх С.Энхцэцэг, О.Дондогмаа дарга ороод ирсэн байна, Улсын Их Хурлын Тамгын газрын байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна аа.

Хууль зүйн зөвлөмжийн талаар асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье.

Сандаг-Очиороор тасаллаа. Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Энэ би өглөө орж ирэхэд 3 асуудалтай байсан чинь 4 дэх нь гээд ороод ирж. Орж ирж гэж бодъё. Тэгэхдээ энэ хэзээ ямар ийм жишиг хууль гарч ирсэн билээ би сайн мэдэхгүй байна. Тэр хавиараа ингээд л иймэрхүү техникийн шинжтэй юм бол тэр хавиараа өргөн барьсан нөхдүүд энэ тэр нь засаад л явчихдаг юм уу? Байнгын хороон дээр. Энэ яахаараа ингээд манай Байнгын хороон дээр нэг энэ хуулийн хүчинтэй байх хугацааг бид нар лавлагаа гаргаж өгнө гэж юу гэсэн үг юм? Би жоохон ойлгосонгүй. Энэ манай 2 хүний хэлж байгаагаар бол хууль чинь ердийн тохиолдолд энд хүчинтэй болно эсвэл хугацаа давчуу тэгээд хүчинтэй болно гэж байгаа биз дээ.

Тэгээд л 30 онд дуусна гээд биччихсэн л тийм. Би ер нь ойлгохгүй байна.

Нэгдүгээрт та нар энэ бас нэг юм хэлье. Манай Хууль зүйн дарга юм битгий ингэж цагийг нь тулгаж тарааж бай л даа. Өглөө орж ирээд ирцэд ороход байхгүй байснаа тэгээд шууд 4 дүгээр асуудал болгоод тавьчих юм. Жаахан замбараатай юмаа хийвэл яасан юм. Энэ Их Хурал чинь ингээд хэдүүлээ нэг юмаа ойлгоод энэ нэг хэдэн цаасыг чинь ядаж нэг уншдаг юм уу? Мэдэхгүй бол хүн амьтны цаас бичээд орж ирмээр байна шүү дээ. Нэг ийм гэв гэнэтхэн сюрприз бариад байх юм.

Та 2 тэгээд бас ямар юм зөвлөөд байгааг чинь ерөөсөө ойлгосонгүй. Энэ 30 оны энд бас ямар хамаатай юм? Би энэ Байнгын хорооны нөгөө даргынх нь бичгийг уншаад ерөөсөө ойлгохгүй юм. Энэ ер нь ямар юм болоод байгаа юм бэ? Хууль чинь ердийн журмаар хүчин төгөлдөр болно эсвэл тэдэн сарын тэднээс эхлээд хүчин төгөлдөр болно гээд л болоо биз дээ? Ойлгодоггүй ээ дарга аа хэнээс асуухаа бас мэдэхгүй байна.

Та нар маань нэг тайлбарлаадхаач. Хэдүүлээ ийм хэрэгтэй хэрэггүй ажил хиймээргүй байна шүү дээ болимоор байна.

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон Дондогмаа даргын микрофоныг өгье.

Ч.Дондогмаа: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Алтанхуяг гишүүний асуултад хариулъя.

Манай Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах асуудлыг зохицуулсан байгаа дэгийг зохицуулсан. Энэ 42 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт холбогдох Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа дараах тохиолдолд санал хураалт явуулж болно оо гээд 42.2.2-т анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал болон хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо эсхүл бусад хуультай зөрчилдсөн талаарх хууль зүйн зөвлөмжийг ХЗБХ дэмжиж санал, дүгнэлт гаргасан тохиолдолд холбогдох Байнгын хороо эцсийн хэлэлцүүлгийн шатдаа санал хураалт явуулж болно оо гэсэн ийм зохицуулалт байгаа юм аа.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн талаар хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороо анхны хэлэлцүүлгийг хийгээд эцэслэн батлах горимын саналтайгаар нэгдсэн хуралдаанд оруулсан. Эцэслэн батлах горимын санал нэгдсэн хуралдаан дээр дэмжигдээгүй. Үүнтэй холбогдуулан Эдийн засгийн байнгын хороо энэ хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явуулахаар төлөвлөгдсөн байгаа.

Энэ хууль дээр ямар асуудал гарсан бэ гэвэл Засгийн газраас хуулийн төслийг өргөн мэдүүлэхдээ хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгаагүй. Үйлчилж дуусах хугацааг тусгачихсан байгаа. Өөрөөр хэлбэл 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд үйлчилнэ ээ гэж тусгасан хэр нь ээ хэзээнээс эхлэх хугацааг тусгаагүй. Энэ нь яаж байгаа вэ гэхээр хууль тогтоомжийн хуульд хуулийн төсөлд хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг тусгана.

Мөн хууль боловсруулах аргачлал дээр юу гэсэн бэ гэхээр хуулийг зөвхөн тодорхой хугацаанд үйлчлэхээр байвал түүний хүчин төгөлдөр болох болон хүчин төгөлдөр үйлчилж дуусгавар болох огноог хуульд нь тусгана аа гэсэн. Тэгтэл энэ хууль маань дуусах хугацаа буюу 2030 он хүртэлх хугацааг заасан хэрнээ эхлэх хугацааг тусгаагүй байгаад байгаа.

Энэнтэй холбогдуулан хуулийн нийцлийг хангах зорилгоор Тамгын газраас зөвлөмж гаргасан. Энэ энэ зөвлөмжийн талаар ХЗБХ санал, дүгнэлт гаргавал холбогдох Байнгын хороо буюу Эдийн засгийн байнгын хороо санал хураалт явуулах эцсийн хэлэлцүүлгийн шатад явуулах боломж гарч байгаа юм.

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүн тодруулж асууя.

Н.Алтанхуяг: Хэдүүлээ ингээд шийдэж болохгүй юм уу? Энэ хуулийн бүрдэл гэж нэг юм харах ёстой шүү дээ. Их Хуралд өргөн барьж байгаа хууль. Засгийн газар ч гэсэн тэрийгээ тэр шаардлагынхаа дагуу өргөн барь. Хэн нэгний дутуу хийсэн ажлын төлөө бид нар энэ дээр дүгнэлт гаргана гэж сууна гэж ерөөсөө байхгүй ээ нөхдүүд үндсэн ажлаа хийе. Тэгээд тэрний нэг хэзээ эхлэх мэхлэх чинь тийм их нарийн дүгнэлт гаргадаг ч асуудал бас биш 1 дүгээр ангийн хүүхэд ойлгоно шүү дээ наадах чинь. Засгийн газар ингээд би ойлгосон зөв үү хэн Дондогмаа. Энэ ингээд Засгийн газар энийгээ өргөн барихдаа тэгээд хэднээс эхлэхийг нь бичээгүй юм байна. Үгүй ээ тэгээд тэр бид нарт ямар хамаатай юм. Буцаад өгөөд бичүүлээд л ав л даа. Энэ чинь ямар дүгнэлт гаргах асуудал биш шүү дээ. Нэг дээр нэгийг нь нэмлээ, 2 гарна гүйцээ буцаагаад өг.

Бид нар үндсэн ажлаа хийе. Эсвэл тэр Байнгын хороон дээр нь зарчмын зөрүүтэй саналыг нь гаргуулаад хураалгаад тэгээд хийчих. Болохгүй юм уу?

Д.Цогтбаатар: 3 дугаар микрофон гүйцээгээд хариулах уу?

Ч.Дондогмаа: Хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороогоор анхны хэлэлцүүлэг хийх үед зарчмын зөрүүтэй санал гараагүй. Эцэслэн батлах горимын саналтай байсан юм.

Тэгэхээр одоо эцсийн хэлэлцүүлгийн шатанд бол анхны хэлэлцүүлгийн шатанд зарчмын зөрүүтэй санал гараагүй тохиолдолд бас санал гаргаж хураах боломжгүй нөхцөл байдал үүссэн. Одоо санал хураах боломж нь зөвхөн энэ хууль зүйн зөвлөмжийг Хууль зүйн байнгын хороо санал, дүгнэлт гаргаж дэмжсэн тохиолдолд гэсэн ийм манай дэгийн хуулийн зохицуулалт байгаа юм аа.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Алтанхуяг гишүүн ээ энэ дээр яах вэ эрх зүйн хувьд яах аргагүй таны хэлж байгаа нөхцөл байдлууд үүсэж байгаа нь үнэн. Гэхдээ бид нар энэ дээр нэг юм нь хуулийнхаа дагуу нээрээ хэрэв эцэслэн заасан хугацаатай бол зүгээр л хуулийн эхлэх хугацаагаа заавал зааж өгөх заалттай хуультай л байгаа байхгүй юу. Тэр нь зөрчигдсөн байна аа гэдэг зөвлөмжийг нь бид нар гаргах нь угаасаа л хуулийнхаа л дагуу л тийм юм байгаа юм.

Тэгэхээр тэрийг нь гаргаж өгөөд тэр холбогдох Байнгын хороо нь энийгээ хэлэлцээд явна биз. Бид нар бол хуулийнхаа хүрээнд л энэ чинь ийм байна шүү гэдгийг нь гаргаж өгөөд л цаашаа холбогдох Байнгын хороо нь аваад л яваг. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Гишүүд сая санал хураалтдаа бэлдсэн байгаа.

Ингээд би саналын томьёоллыг танилцуулъя.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт энэ хууль 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд үйлчилнэ гэж тусгасан нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль хүчин төгөлдөр болох хугацааны тухай зохицуулалттай нийцэж байгаа эсэх талаар хууль зүйн зөвлөмжийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

57.1 хувиар санал дэмжигдлээ.

Хууль зүйн зөвлөмжийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн дагаж мөрдөх хугацаа нь тодорхой бус байх нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.3.9 дэх заалттай

тус тус зөрчилдсөн эсэх талаарх хууль зүйн зөвлөмжийг Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа танилцуулна аа.

Ингээд Дондогмаа даргын микрофоныг өгье. 3 дугаар микрофон.

Ч.Дондогмаа: Хууль зүйн зөвлөмжийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргуулахаар Төсвийн болон БОХХАА-н байнгын хорооноос Улсын Их Хурлын Тамгын газарт 2025 оны 12 дугаар сарын 8-ны өдөр ирүүлсэн дугаартай албан бичиг Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 2.2 дахь заалтын дагуу энэхүү хууль зүйн зөвлөмжийг гаргав.

Тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн дагаж мөрдөх хугацаа нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль хүчин төгөлдөр болох хугацааны тухай зохицуулалттай нийцэж байгаа эсэх талаар.

Өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн 5 дахь заалтад энэ тогтоолыг 2025 оны цэг, цэг, дүгээр сарын цэг, цэг-ний өдрөөс эхэлж дагаж мөрдсүгэй гэж заасан. Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг 2025 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулах үед уг тогтоолын төслийн хэрэгжих хугацааг ердийн журмаар мөрдөх талаар буюу төслийн 5 дахь заалтыг хасах санал гаргасан боловч хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй байна аа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.5-д тогтоолын төсөл дараах бүтэцтэй байна. Шаардлагатай бол тогтоол хүчин төгөлдөр болох хугацааг заана аа гэж заажээ. Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй ийнхүү нийтэлснээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5.3-д тухайн хуульд тогтоомжид өөрөөр заагаагүй бол уг шийдвэр төрийн мэдээлэл эмхэтгэлд албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно гэж тус тус заасан. Гэтэл тогтоолын төслийн 5 дахь заалтын талаар гарсан зарчмын зөрүүтэй санал буюу хэрэгжих хугацааг ердийн журмаар мөрдөх талаарх санал чуулганы нэгдсэн хуралдаанаар дэмжигдээгүй тул энэ тогтоолыг 2025 оны цэг, цэг, дүгээр сарын цэг, цэг өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн дагаж мөрдөх хугацааны хувьд тодорхойгүй заалт хэвээр үлдэх болсон байх тул хүчин төгөлдөр болох хугацааг тодорхой тогтоох шаардлага үүссэн.

Иймд:

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Төсвийн болон БОХХАА-н байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хийхдээ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2-т заасны дагуу Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн төсөлд хүчин төгөлдөр болох, хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацааг нэмж тусгах нь зүйтэй байна аа.

Санал зөвлөмж.

Нэгдүгээрт Тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хүчин төгөлдөр болох хугацааг нэмж тусгах, эсхүл төслийн 5 дахь заалтыг хасах.

Хоёрт, хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь 2-т заасны дагуу хийхийг зөвлөж байна. Танилцуулж дууслаа.

Д.Цогтбаатар: Дондогмаа даргад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Би түр танилцуулсан. Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ц.Дондогмаа. Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын ахлах зөвлөх Бямбадулам нар оролцож байна аа.

Хууль зүйн зөвлөмжийн талаар асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Алга байна. Гишүүд тэгвэл ингээд асуух асуулт байхгүй байна. Түрүүн асуулт асуугаад хариултаа авчихсан. Ер нь агуулга 1-тэй байгаа.

Тэгэхээр санал хураалтдаа бэлдье гишүүд.

Санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн тогтоолд нэмэлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг дагаж мөрдөх хугацаа нь тодорхой бус байх нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.3.9 дэх заалттай тус тус зөрчилдсөн гэсэн хууль зүйн зөвлөмжийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

64.3 хувиар санал дэмжигдлээ.

Хууль зүйн зөвлөмжийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг төсвийн болон Бай БОХХАА-н байнгын хороонд хүргүүлнэ ээ.

12.12 цаг

Дараагийн 2 дахь асуудалдаа оръё. [Байнгын хорооны тогтоолын төсөл ажлын хэсэг байгуулах тухай.](#)

Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулна аа. Тогтоолын төслийг тараасан байгаа. Гэхдээ би уншаад танилцуулчихъя. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. 2025 оны ... дугаар сарын ... өдөр ... дугаар Улаанбаатар хот.

Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, мөн 20 хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга Г.Уянгахишиг, Монгол Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүд О.Номинчимэг Монгол Улсын Их Хурлын гишүүн Өргөдлийн байнгын хорооны дарга, О.Алтангэрэл Монгол Улсын Их Хурлын гишүүн, Х.Баасанжаргал Монгол Улсын Их Хурлын гишүүн, П.Сайнзориг Монгол Улсын Их Хурлын гишүүн, С.Одонтуяа Монгол Улсын Их Хурлын гишүүн, Г.Уянгахишиг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Д.Пүрэвдаваа Монгол Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг Ажлын хэсэгт зөвшөөрсүгэй. Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гэж тогтоол байгаа.

Тогтоолын төслийг сая уншиж танилцууллаа. Та нар ч бас тараачихсан байж байгаа. Асуулт асууж, хариулт авч үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. Алга байна.

Тэгвэл ингээд санал хураалтдаа оръё. Саяын энэ уншиж танилцуулсан төслийг ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтдаа гишүүд бэлдье. Би ажлын хэсгийн бүрэлдэхүүнээ дахиад уншихгүй бол Уянгахишиг гишүүнийг би 2 уншчихсан байна шүү. Ажлын хэсгийн ахлагч Г.Уянгахишиг Монгол Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүд дандаа Улсын Их Хурлын гишүүд байгаа. О.Номинчимэг Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга, О.Алтангэрэл Улсын Их Хурлын гишүүн, Х.Баасанжаргал Улсын Их Хурлын гишүүн, П.Сайнзориг Улсын Их Хурлын гишүүн, Х.Тэмүүжин Улсын Их Хурлын гишүүн, Д.Пүрэвдаваа Улсын Их Хурлын гишүүн гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байгаа шүү.

Ингээд “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя санал хураалт.

71.4 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

12.18 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Гурав дахь асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл. Ажлын хэсэг байгуулах тухай.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа. Гэхдээ уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 2025 оны ... дугаар сарын ... тэдний өдөр. Дугаар, Улаанбаатар хот.

Ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос тогтоох нь:

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол. Би түрүүн уншиж танилцуулсан байсан.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч О.Алтангэрэл Монгол Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүд О.Номинчимэг Монгол Улсын Их Хурлын гишүүн Өргөдлийн байнгын хорооны дарга, Х.Баасанжаргал Монгол Улсын Их Хурлын гишүүн, П.Сайнзориг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Х.Тэмүүжин Монгол Улсын Их Хурлын гишүүн, Г.Уянгахишиг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Д.Пүрэвдаваа Монгол Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй.

Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гэсэн байна аа.

Ингээд энэ уншиж танилцуулсан тогтоолыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

64.3 хувиар санал дэмжигдлээ.

Одонтуяа гишүүн бас яг энэ дээр нэг эрэгтэй хүнээр Гэр бүлийн хуулийг тэгж ярьсан юм. Ингээд л явчихна. Ингээд санал хураалтын дүнг танилцуулсан.

Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэж шийдвэрлэлээ.

12.21 цаг

Ингээд Байнгын хорооны тогтоолын төсөл Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Байнгын хорооны тогтоолын төслийг бас тараасан байж байгаа. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

2025 оны дугаар ... сарын ... ний өдөр, дугаар, Улаанбаатар хот гэсэн байгаа.

Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тов тогтоох, сонсголын даргалагчийг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, 30.3, 30.4 дэх хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5.2 дахь заалтыг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос тогтоох нь:

ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчтэй хийх томилгооны сонсголыг 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулахаар тогтсугай.

2.Нэр дэвшигчийн томилгооны сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуягийг томилсугай.

3.Нэр дэвшигчийн томилгооны сонсголын талаар нийтэд мэдээлэх сонсголын бэлтгэл хангах ажлыг холбогдох хууль журамд заасны дагуу зохион байгуулахыг Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатарт даалгасугай.

Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гэсэн байна аа.

Ингээд энэ уншиж танилцуулсан томьёоллоор нэр дэвшигчийн томилгооны сонсголын тов тогтоох сонсголын даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэж санал хураалт явуулъя аа.

Санал хураалт. Сонсголын тов тогтоох сонсголын даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэж санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

Алтанхуяг гишүүнд юу микрофон өгье.

Н.Алтанхуяг: Намайг тавих гэж байгаад их баярлаж л байна л даа. Тэгэхдээ асуудал наадах чинь буруу явчих болов уу гэж би зүгээр болгоомжилж байна. Энэ чинь ингэсэн шүү дээ. Бид нар нэг ажлын хэсэг гаргаад явуулсан чинь тэд нар чинь 24 хүнээс бид нарт 4 хүн өгчхөөд байгаа. Одоо бид нар тэр 4 хүн дээр нь нэг сонсгол зохион байгуулах болчихоод байгаа байхгүй юу. Гэтэл ямар маргаан тэмцээн гарчихсан гэхээр тэр цаана үлдчихсэн хүмүүс чинь энэ та нар энэ дөрөвхөн хүн гаргаад авчихдаг олонхын санал авчхаад. Дөрөвхөн хүнийг авчихна. Та нар 4 хүний орон тоон дээр 4 хүн гаргаад өгчихсөн ийм маргаантай байгаа байхгүй юу. Уг нь бол хуулиа үзвэл бид нар 6 хүн оруулж ирэх ёстой. Гэтэл эд нарын хэлээд байгаа нөгөө талаасаа зөв байгаа. 4, 5, 6 дахь хүн чинь олонхын санал аваагүй тэрнээс доош олонхын санал аваагүй учраас 4 орохоос биш яах вэ гээд ингээд нэг гэнэн цайлган тайлбар хийгээд байгаа юм. Энэ бол би шударга ёсны үүднээс их муу юм болж л гэж бодоод байгаа юм. Би энэ сонсголыг даргалах гэхээр би өөрөө өөрсдийнхөө зарчимтай зөрчилдөөд байгаа юм.

Юм хум даргал гэхлээр бас даргалчихмаар санагдаж л байна л даа зүгээр тэгэхдээ энэ тэгээд дараа нь энэ 4 хүнийг чинь 24-өөс чинь бид нар дөрвийгөө ингээд хүлээн зөвшөөрөөд аваад явчхаж байгаа байдал үүсчхээд байна шүү дээ.

Би юу гэж ойлгоод байгаа вэ гэхлээр тэр анхны тэр ажиллагаагаа дахиж хиймээр байна шүү дээ. Гомдол тэмцэлтэй байхад чинь. Тэгвэл би энэнд чинь цааргалахгүй. Одоо тэгээд та нар өөрснөө учраа ол. Би та нарт нэг ийм юмаа зөв болгох байлгах тийм л арга зам л санал хэлж байна шүү дээ. Тэгээд би ямар шийдвэр гаргах биш. Та нар маань өөрөө яриад шийднэ биз. Ер нь шударга бус. Шударга бус гэдгийг би тэр 4 хүнийг нь мэдэхгүй тэр бүгдийг нь яриагүй. Процекураа бид нар хуулийнхаа дагуу явуул гээд өгсөн. Нөгөөдүүл чинь явуулсан гэж байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүдийн эрхийг тэнд 11 хүн авчхаад, тэгээд баахан хэл амтай юм хийчихсэн. Зүгээр жаахан сайхан нуруутай шударга гаргаад л ирнэ л биз дээ. 6 хүн бид нарт өгчих л биз дээ. Ер нь ингээд бодохоор дахиад бид нар хуульдаа байна уу, Энхбаяр сайдыг би мэдэхгүй байна. Энийг тэд нар луу өгөөд байгаа эрх чинь аягүй буруу байна шүү дээ. Тэд нар бүр бид нарт ингээд уншсан би тэр протоколыг тэгсэн чинь ингээд энэ 3 тэр тэр хүмүүсийг тэд нар ингээд ингээд явчхаж. Тэгэхгүй шүү дээ бүгдээрээ л оролцох ёстой шүү дээ. Тэгээд дараа нь саналаа өгөх болохоороо шалгаруулаагүй хүнийхээ төлөө яаж санал өгөөд байгаа юм? Би бас ойлгохгүй байна. Ингээд явсаар байгаад мань хэдийн гаргасан хууль бол уг нь их зөв. ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнийг Их Хурлаар оруулаад олон нийтийн нүдэн дээр сайхан асуулт хариулт нээлттэй явуулаад болохгүйг нь болохгүйг нь гээд явуулъя гэсэн чинь ерөөсөө ингээд 24-өөс нь 4-ийг нь өгчихдөг. Одоо 4 дээр яаж сонсгол явуулах юм. Та нар юм бодож байна уу? Хэдүүлээ зөвлөө гээд байхгүй юу. Би нэг их эсэргүүцээд байгаа юм алга. Би дээр таныг хэлэхээр нь бас нээрээ ингээд явах юм байх гэсэн чинь ийм зөрчил үүсэж байна шүү дээ. 6 хүнтэй бол ядаж болж байна л даа. 6 хүн дээрээ хэдүүлээ сонсголоо хийгээд наана цаана болгоод ингэнэ биз. Тэр цаана үлдсэн гомдлыг нь дахиад ярина л биз. Яасан дээр вэ Цогтбаатар дарга аа? Би ийм ийм онцгүй байдалтай бол би тэрийг даргалж. Тэгэнгүүт дараа нь хар аа их онигоотой юм болно. 4 хүнээ сонсгол хийчхээд энд орж ирээд кнопоороо ингэсэн чинь бас унагаагаад энэ баахан хүний ажил алаад байгаа байхгүй юу. 4 хүнийг горьдоогоод. Яаж мэдэж байгаа юм нэг юм уу 2-ыг нь сонгох юм. Бид нар хэлж мэдэхгүй шүү дээ. Олон түмний өмнө наана чинь нээлттэй сонсгол явна шүү дээ одоо. Сонсголын дараа санал хураана биз дээ. Тэгэхээр чинь сонсгол зохион

байгуулаад олон түмний өмнө баахан 4 хүнийг хамар амнаас нь татаад ерөөсөө элдэв юм болчхоод тэгээд оруулж ирээд унагаагаад.

Д.Цогтбаатар: Ингээд юу асуулт асууж, үг хэлж дууслаа. Ингээд санал хураалтдаа бэлдье гишүүд. Тэгвэл манайхан бүгдээрээ дэмжээд өгөөрэй. Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тов тогтоох, сонсголын даргалагчийг сонгох тухай байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

57.1 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ. Ингээд Байнгын хорооны хурал өнөөдөр хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан тул хурал дууслаа. Хурлыг хаалаа.

12.36 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА